

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ГУЧИНДОЛДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны арваннэгдүгээр сарын 24-ны 14 цаг 10 минутад эхэлж, 16 цаг 44 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 34 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “б”, Сонгон шалгаруулах комиссын Д/60 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Доржсүрэнгийн Ганцэцэгийг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбатад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
2	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга зэрэг албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/61 дүгээр дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Мижидсүрэнгийн Энх-Амарыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулгад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/62 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:

Лхасүрэнгийн Чой-Ишийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулгад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/63 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:

Цэндгомбын Болорчулууныг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулгад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/64 дүгээр дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:

		<p>Дэмбэрэлнямын Совдыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулгад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов</p>
3	<p>Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын дарга, Уул уурхайн бодлогын газрын дарга, Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга зэрэг албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 03/810 тоот албан бичгээр ирүүлсэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газрын даргын, Уул уурхайн бодлогын газрын даргын, Хүнд үйлдвэрийн бодлогын газрын даргын албан тушаалд тус тус томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
4	<p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга зэрэг албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулгын 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1136 тоот албан бичгээр ирүүлсэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд тус тус томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
5	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярын 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 1/1078 тоот албан бичгээр ирүүлсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>

6	Архангай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Архангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Өсөхбаярын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 134 тоот албан бичгээр ирүүлсэн Архангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.
7	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Соёл, урлагийн бодлогын газрын дарга, Шинжлэх ухаан, технологийн бодлогын газрын дарга, Биеийн тамир, спортын бодлогын газрын дарга зэрэг албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах	<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайханы 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 2/3671 тоот албан бичгээр ирүүлсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Биеийн тамир, спортын бодлогын газрын дарга зэрэг албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p> <p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Соёл, урлагийн бодлогын газрын дарга, Шинжлэх ухаан, технологийн бодлогын газрын дарга зэрэг албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлахыг хойшлуулахаар шийдвэрлэв.</p>
8	Хөвсгөл аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх мэргэшлийн шалгалтын дүн	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Хөвсгөл аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1.Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 50 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх</p>

		<p>орох иргэний нөөц"-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 32 иргэнийг "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д тус тус бүртгэх</p> <p>2.Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан гуравдугаар хавсралтад дурдсан нэр бүхий 11 иргэнийг, "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан дөрөвдүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 4 иргэн, нийт 15 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 15 иргэнийг "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөл /Г.Төмөрбаатар/-д, үүрэг болгох</p> <p>4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамба даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов</p>
9	Зарим хүмүүсийг "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 2.2.9, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан дараах нэр бүхий 26 төрийн албан хаагчийг Монгол Улсын "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнах</p>

		<p>2. "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнагдсан хүн тус бүрт уг шагналыг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг шагнуулахаар нэр дэвшүүлсэн тухайн байгууллага Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам"-ын 4.2-т заасны дагуу шийдвэрлэх</p> <p>3. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 2.2.9, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам"-ын 3.1.11-д заасныг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачлагатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Банзаарайн Нэргүйг Монгол Улсын "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнах</p> <p>2. "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнагдсан Б.Нэргүйд уг шагналыг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам"-ын 4.2-т заасны дагуу шийдвэрлэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
10	Төрийн албаны зөвлөлийн Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг",</p>

		<p>Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлах</p> <p>Салбар зөвлөлийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн нарийн бичгийн дарга,</li> </ul> <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн захиргааны удирдлагын газрын дарга</li> <li>- Хууль зүйн бодлогын газрын дарга</li> <li>- Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга</li> <li>- Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга</li> <li>- Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын дарга,</li> </ul> <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн.</li> </ul> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 4 дэх хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын “Нэг”-ийн 12 дахь хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн Хууль зүйн яамны дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг өөрчлөн томилох тухай” мөн Зөвлөлийн 2015 оны 33 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
11	Төрийн албаны зөвлөлийн Зам, тээвэр, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Салбар</p>

		<p>зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлах Үүнд: Салбар зөвлөлийн дарга: - Төрийн нарийн бичгийн дарга, Гишүүд: - Төрийн захиргааны удирдлагын газрын дарга - Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, - Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, - Хуулийн хэлтсийн дарга, - Зам, тээврийн хяналтын хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга - Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн.</p> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 8 дахь хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын “Нэг”-ийн 6 дахь хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргыг томилж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” мөн Зөвлөлийн 2015 оны 59 дүгээр тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн Зам, тээврийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” мөн Зөвлөлийн 2015 оны 161 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
12	Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлах Үүнд:</p>



		<p>Салбар зөвлөлийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн нарийн бичгийн дарга,</li> </ul> <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн захиргааны удирдлагын газрын дарга</li> <li>- Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга,</li> <li>- Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга,</li> <li>- Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга,</li> <li>- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга</li> <li>- Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга</li> <li>- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга</li> </ul> <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн</li> </ul> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 1 дэх хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын “Нэг”-ийн 1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
13	Төрийн албаны зөвлөлийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн :</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлах Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн нарийн бичгийн дарга,</li> </ul> <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн захиргааны удирдлагын газрын дарга</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Геологийн бодлогын газрын дарга</li> <li>- Түлшний бодлогын газрын дарга</li> <li>- Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга</li> <li>- Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга</li> <li>- Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга</li> <li>- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга,</li> </ul> <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн</li> </ul> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 10 дахь хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын “Нэг”-ийн 9 дэх хэсэг, ““Төрийн албаны зөвлөлийн Уул уурхайн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай”” мөн Зөвлөлийн 2015 оны 139 дүгээр тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргыг томилж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” мөн Зөвлөлийн 2015 оны 41 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
14	Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг” Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлах. Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Газрын дарга,</li> </ul> <p>Гишүүд:</p>

		<ul style="list-style-type: none"> <li>- Газрын Дэд дарга</li> <li>- Тамгын газрын дарга</li> <li>- Шалган нэвтрүүлэх газрын дарга</li> <li>- Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга</li> <li>- Хүний нөөц, сургалтын хэлтсийн дарга</li> <li>- Санхүүгийн хэлтсийн дарга</li> <li>- Дүн шинжилгээ, мэдээллийн албаны дарга</li> </ul> <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүний нөөц, сургалтын хэлтсийн Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн</li> </ul> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Хоёр”-ын 8 дахь хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 7 дахь хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын дэргэдэх салбар зөвлөлийн нэр, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” мөн Зөвлөлийн 2015 оны 106 дугаар тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргыг томилж, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” мөн Зөвлөлийн 2016 оны 05 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов</p>
15	Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлах Үүнд: Салбар зөвлөлийн дарга</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга,</li> </ul> <p>Гишүүд:</p>

		<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга</li> <li>- Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга,</li> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,</li> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга,</li> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,</li> <li>- Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дарга,</li> <li>- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга,</li> <li>- Нийслэлийн Боловсролын газрын дарга</li> <li>- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга</li> <li>- Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрындарга</li> <li>- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга</li> <li>- Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга</li> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн мэргэжилтэн</li> </ul> <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэл дэх орон тооны нарийн бичгийн дарга</li> </ul> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 22 дахь хэсэг, “Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргыг томилох тухай” мөн Зөвлөлийн 2013 оны 77 дугаар тогтоол, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай” мөн Зөвлөлийн 2013 оны 78 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов</p>
16	<p>Бусад асуудал</p> <ul style="list-style-type: none"> <li>- Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны</li> </ul>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах</p>

<p>зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <p>- Үндэсний хөгжлийн газрын Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>журам"-ын 14 дүгээр зүйлийн "б", Сонгон шалгаруулах комиссын Д/65 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Сэдбазарын Манлайг Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбатад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14 дүгээр зүйлийн "а", Сонгон шалгаруулах комиссын Д/66 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Гүндэгмаагийн Жаргалсайханыг Үндэсний хөгжлийн газрын Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
--	--

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
АЖЛЫН АЛБА**